



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 03 өдөр

Дугаар А/173

Бат-Өлзий сум

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай” 2021 оны 6/02 дугаар тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийх тухай” 2022 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 07/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт Галсан-Ёндон овогт Мөнхдаваагийн Ганчимэгт гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 2638386 төлөвлөлтийн нэгж талбарын дугаартай 1253 м² газрыг, иргэн Пунцаг овогт Энхбатын Энхбаатарт гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 2680618 төлөвлөлтийн нэгж талбарын дугаартай 700 м² газрыг, иргэн Өндөр наваан овогт Сүхбатын Даш-Өлзийд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 2697102 төлөвлөлтийн нэгж талбарын дугаартай 700 м² газрыг тус тус 40 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрх авсан иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, гэрчилгээ олгож, газрын улсын бүртгэлд бүртгэн, хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (И.Маралмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН